

Жилийн үйл ажиллагааны тайлагнал

/маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

2023 оны үйл ажиллагааны тайлан

Тайлагнах хугацаа	2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Техник импорт ХК, УБГД: 9010001041 ҮЦК: 441 Утасны дугаар: (+976) 70001830,	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын Хөрөнгийн Бирж” ХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Гадаад худалдаа	
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Лидер экаунт аудит ХХК 2023.03.07.	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	144,675.5	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албантушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий ня-бо ТУЗ-ын н.б.д Хянасан: Гүйцэтгэх захирал	С. Дашдулам О. Бүжинлхам Д. Ганцэцэг
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайланг хавсаргав.
	Орлогын тайлан	Тайланг хавсаргав.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайланг хавсаргав.
	Мөнгөн гүйлгээний тайлан	Тайланг хавсаргав.
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	Бидний дүгнэлтээр, Техник импорт ХК-ийн 2023 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба өмчийн өөрчлөлт,	

	<p>мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.</p>	
1.2.	<p>Аудитын тодорхойлох захидлыг хавсаргав.</p>	
2.	<p>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл</p>	
2.1.	<p>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</p>	<p>Тайлант хугацаанд: Техник импорт ХК нь 2023 оны санхүүгийн жилд 179 тэрбум 707 сая төгрөгийн борлуулалтын орлого олсон нь өмнөх оноос 31 тэрбум 758,2 сая төгрөгөөр буюу 15%-иар буурсан байна. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 27 тэрбум 816,5 төгрөгөөр буюу 14,4%-иар буурсан нь борлуулалтаас олсон ашиг 14 тэрбум 291,7 төгрөг болж өмнөх оноос 3 тэрбум төгрөгөөр буюу 22%-иар буурсан. Үндсэн бус үйл ажиллагааны орлого 690,3 сая төгрөг болж урьд оноос 3%-иар буурсан. Үндсэн үйл ажиллагааны зардал 9 тэрбум 249,5 сая төгрөгт хүрч урьд оноос 4,5%-иар өссөн байна. Гадаад валютын ханшийн алдагдал 99,1 сая төгрөгт хүрчээ. Татварын өмнөх ашиг 5653,5 сая төгрөг болж өмнөх оноос 4407,5 сая төгрөгөөр буурсан. Улсын төсөвт ААНОАТ-т 565,2 сая төгрөг төлөхөөр, тайлант үеийн цэвэр ашиг 5088,3 сая төгрөг болж өмнөх оноос 3 тэрбум 318,7 төгрөгөөр буурсан байна. 2023 онд тус компани нь улсын төсөвт 17 тэрбум 824,5 сая төгрөгийн татвар төлжээ. Үл хөдлөх хөрөнгийн татварт- 39,9 сая төгрөг ААНОАТатварт-1,607,7 сая төгрөг НӨАТатварт-14 тэрбум 650,7 сая төгрөг Гаалийн татварт-980,3 сая төгрөг НДШ-375,1 сая төгрөг Бусад татварт-125,9 сая төгрөг Газрын төлбөрт- 44,9 сая төгрөг тус тус төлсөн байна. Эргэлтийн хөрөнгө оны эцэст 97 тэрбум 900,219,878.71 сая төгрөг байна. Үүнд: Мөнгөн хөрөнгө - 858,9 сая Бараа материал 21 тэрбум 643,9 сая Авлага- 75 тэрбум 395,1 сая төгрөг байна. Дансны өглөг урьд оноос 8 тэрбум 813,4 сая төгрөгөөр нэмэгдэж 74 тэрбум 985,4 сая төгрөг болжээ.Үүнээс банкны богино хугацаат зээлийн өглөг 34 тэрбум 796,5 сая төгрөг болж урьд оноос 272,8 сая төгрөгөөр буурсан байна. Эргэлтийн хөрөнгөөр өр төлбөрөө төлөх боломж: 97 тэрбум 900,2 сая төгрөг /эргэлтийн хөрөнгө/-74 тэрбум 985,4 сая төгрөг / өр төлбөр/=22 тэрбум 914,8 сая төгрөг болж байгаа нь төлбөрийн чадвар</p>

		<p>Цаашид санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд анхаарах зүйл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Бараа материалын нөөцийг эргэлтэнд оруулж мөнгөн эргэлтийн хөрөнгийг түргэсгэх ✓ Дансны авлага 58 тэрбум 862,5 сая төгрөг байгааг анхаарч шуурхай барагдуулах арга хэмжээ авч банкны богино хугацаат зээлийн үлдэгдлийг бууруулах, ✓ Улирал тутам компанийн санхүүгийн тайланд эдийн засгийн дүн шинжилгээ хийж цаашид хийх ажлыг төлөвлөж ажиллах, ✓ Бараа материал хариуцсан менежерүүд импортоор болон дотоодоос нийлүүлж байгаа барааны зах зээл, валютын ханшийн өөрчлөлт, эрэлт нийлүүлэлтэнд судалгаа хийж ажиллах хэрэгтэй байна. <p>Компанийн 2023 оны нийт борлуулалтын орлогыг өмнөх онтой харьцуулж үзэхэд</p> <ul style="list-style-type: none"> ➢ 2022 онд 211 тэрбум 465,4 сая ➢ 2023 онд 179 тэрбум 707,2 сая төгрөг болсон байна. <p>Борлуулалтаас олсон ашиг:</p> <ul style="list-style-type: none"> • 2022 онд 18 тэрбум 233,5 сая төгрөг • 2023 онд 14 тэрбум 291,7 сая төгрөг болсон байна. <p>Татвар төлөхийн өмнөх цэвэр ашиг:</p> <ul style="list-style-type: none"> ❖ 2022 онд 10 тэрбум 61 сая төгрөг болж 5 тэрбум 250,2 сая төгрөгөөр өссөн бол ❖ 2023 онд 5 тэрбум 653,5 сая төгрөг болсон байна. <p>Татварын дараах ашиг:</p> <ul style="list-style-type: none"> ❖ 2022 онд 8 тэрбум 407 сая төгрөг байсан бол <p>2023 онд 5 тэрбум 88 сая төгрөг болж буурсан үзүүлэлттэй гарсан байна.</p>
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<ol style="list-style-type: none"> 1. Цэвэр эргэлтийн хөрөнгө нь $97900,2 - 74985,4 = 22914,8$ тэрбум төгрөг байгаа нь 2022 оноос 11,8 хувиар өссөн байна. 2. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа $\frac{858,9 + 75395,1}{74985,4} = 1,02$ Энэхүү 1-ээс дээш үзүүлэлттэй байгаа нь компанийн төлбөрийн чадвар сайн байгааг харуулж байна. 3. Эргэлтийн харьцаа нь $\frac{97900,2}{74985,4} = 1,3$ нь эргэлтийн хөрөнгөөрөө өр төлбөр барагдуулах чадвар сайн байгааг харуулж байна.

2.3.	<p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<p>Манай компани нь МУ-ын зах зээл дээр нийлүүлэгдэж байгаа битумын 40%-ийг, цементийн 33%-ийг, арматурын 10%-ийг, мотоциклын 38%-ийг эзэлдэг боловч тайлант хугацаанд дараахь хүчин зүйлсийн нөлөөгөөр битум, цемент, мотоцикл, арматурын төлөвлөгөөт нийлүүлэлт, худалдан авалтууд тасарсан үзүүлэлттэй гарсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ханшийн өсөлт /Гадаад валют/ 2. Импортын барааны үнийн өсөлт /мотоцикл, битум/ 3. Инфляцийн өсөлт 4. Бэлэн мөнгөний хомсдол үүссэнээс бараа материал нийлүүлэх хугацаа удааширах, хойшлогдох 5. Байгалийн хүчин зүйлс /Бороо, үер ус/ 6. Хэрэглэгчийн худалдан авах чадваргүй байдал 7. Хөрш орон ОХУ-ын дайны нөлөөгөөр бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт саатах /битум/
2.4.	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</p>	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.</p>
2.5.	<p>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</p>	<p>Тайлант хугацаанд: Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл компанийн Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналын дагуу 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр ТУЗ-ын нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаж Худалдаа хөгжлийн банкнаас эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 35 тэрбум төгрөгийн зээл авах асуудлыг хэлэлцсэн. Тус хурлаас 35 тэрбум төгрөгийг 18 сарын хугацаатай, жилийн 14.4%-ийн хүүтэй авч ашиглах, банкны зээлийн барьцаанд зохих журмын дагуу компанийн үл хөдлөх хөрөнгө, ирээдүйн орлогоос орж ирэх мөнгөн орлогыг барьцаалуулах эрхийг Гүйцэтгэх удирдлагад олгох шийдвэрийг гаргасан. СЗХ-ноос баталсан “Үнэт цаасны журам”-д заасны дагуу болон уг журамд заасан хугацаанд банкны зээлийн талаар хэлэлцсэн компанийн ТУЗ-ын шийдвэр, тогтоолыг холбогдох материалын хамт СЗХ, МХБ ХК-д хүргүүлж журамд заасан үүргээ хэрэгжүүлж ажилласан.</p>
3.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй.

Цалин, урамшууллын мэдээлэл

Тайлант хугацаанд:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд 7 200 000 төгрөгийн цалин олгосон.
2. Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу компанийн ажилтнуудад ажилласан жилийн нэмэгдлийг 2 болон 7-р саруудад олгосон.
3. Инфляцийн өсөлттэй уялдуулан компанийн ажилтнуудын цалинг ажлын үнэлгээнд тулгуурлаж тодорхой хувиар нэмэгдүүлсэн.

Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

Компанийн удирдлагын бүтэц

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал
2. Төлөөлөн удирдах зөвлөл
3. Гүйцэтгэх удирдлага

Хувьцаа эзэмшигчдийн хурал:

Компанийн Дүрэмд “Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна” гэж заасан.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Компанийн тухай хуульд заасны дагуу жил бүр санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулдаг.

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 16 цагт компанийн “Хурлын танхим”-д болсон.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох Хувьцаа эзэмшигчдийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иас гаргасан “Хувьцаа эзэмшигчдийн судалгаа”-ны дагуу бүртгэж баталгаажуулсан.

Компаниас гаргасан нийт энгийн хувьцааны тоо 1,446,755 ширхэг бөгөөд дээрх “Хувьцаа эзэмшигчдийн судалгаа”-гаар 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн бүртгэлийн өдрөөр 459 хувьцаа эзэмшигч компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэгдсэн.

2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 98,8% нь оролцсон.

2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

1. 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт
2. 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, ногдол ашгийн тайлан
3. 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө
4. 2023 оны компанийн бүтэц, зохион байгуулалт
5. 2023 оны компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 98,8% нь оролцсон ба хурлаар хэлэлцэх асуудлуудаар хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахад тус хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид дэмжиж 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

ТУЗ-ын Нэр дэвшүүлэх хорооноос Ж. Баярсайхан, Б.Батсайхан, Б.Нарантуяа нарыг ТУЗ-ын хараат бус гишүүнээр, Д.Баяраа, Т.Тунгалаг, Г.Уран-Өлзий, С.Бүжинлхам, Э.Батболд, Ж.Уртнасан нарыг ТУЗ-ын ердийн гишүүнээр сонгох саналыг 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж баталсан.

ТУЗ-ын Нэр дэвшүүлэх хорооны дүгнэлтээр 2023 оны ТУЗ-ын гишүүнд нэр дэвшигчид нь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй, Компанийн тухай хууль болон

компанийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-д заасан шаардлага, Нэр дэвшүүлэх хорооноос гаргасан үнэлгээний шаардлагыг бүрэн хангасан гэж дүгнэгдсэн.

Компанийн тухай хууль болон компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ын дэргэдэх хороодыг тус тус байгуулж хороодын бүрэлдэхүүнийг томилсон. Үүнд:

1. ТУЗ-ын Аудитын хорооны даргаар Ж. Баярсайхан, гишүүдээр Д.Баяраа, Б.Батсайхан
2. Нэр дэвшүүлэх хорооны даргаар Б.Нарантуяа, гишүүдээр Б.Батсайхан, Г.Уран-Өлзий
3. Цалин, урамшууллын хорооны даргаар Б.Батсайхан, гишүүдээр Ж.Баярсайхан, Т.Тунгалаг нарыг тус тус томилсон.

Төлөөлөн удирдах зөвлөл:

Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн удирдлагыг хэрэгжүүлдэг бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн “Дүрэм” болон “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-аар олгосон эрх, үүргийн хүрээнд:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан шийдвэр, тогтоолыг хэрэгжүүлэх,
2. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох
3. Компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах
4. Компанийн Гүйцэтгэх удирдлагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 6 хараат болон 3 хараат бус нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Компанийн тухай хууль, Компанийн “Дүрэм”, “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-д заасны дагуу

1. Хамтарсан компанийн Гүйцэтгэх удирдлагыг томилох тухай /2023.02.07 №01/
2. Ногдол ашиг хуваарилах тухай /2023.02.15 №02/
2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай /2023.02.15 №03/
3. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын компаниар баталгаажуулах зөвшөөрөл олгох тухай /2023.02.22. №04/
4. Банкнаас зээл авах эрх олгох тухай /2023.05.11 №05/
5. Шагналд тодорхойлох тухай /2023.05.15 №06/
6. Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан журмууд батлах тухай /2023.05.19 №07/

асуудлаар 6 удаа тус тус хуралдаж 100 хувийн ирцтэй, нийт гишүүдийн 100 хувийн саналаар хурлаар хэлэлцэх асуудлыг шийдвэрлэж тогтоол гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Хороод нь өөрсдийн эрхлэх чиг үүргийн хүрээнд дараах асуудлаар хуралдаж санал, дүгнэлт гаргасан. Үүнд:

ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь:

1. 2023 оны ХЭХ-аар ТУЗ-ын гишүүдийг сонгож томилохтой холбогдуулан 2022 онд ТУЗ-ын гишүүдээр ажилласан ТУЗ-ын гишүүдийн үйл ажиллагааны тайлан, ажлын үр дүнг хэлэлцэх, дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах,
2. 2023 оны ХЭХ-аар ТУЗ-ын гишүүдийг сонгож томилохтой холбоотойгоор ТУЗ-ын гишүүдийг бүртгэх, сонгон шалгаруулалт явуулах, ХЭХ-д шууд нэр дэвшүүлэх, бүрэн эрхийн хугацааг сунгах,

ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо нь:

1. Компанийн дотоод аудитын албаны 2022 оны ажлын тайланг хэлэлцэх,
2. 2022 оны компанийн үйл ажиллагааны болон жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх, 2022 оны нэгж хувьцаанд ногдол ашиг хуваарилах эсэх талаар дүгнэлт гаргах,
3. Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит үийх компанийг сонгох

- гэрээ байгуулах,
4. Банкнаас зээл авахтай холбогдуулан компанийн дотоод аудитын албаны үйл ажиллагааны явц, байдалтай танилцах, тус албаны тайлан, мэдээлэлтэй уялдуулан компанийн санхүүгийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэлт өгөх,
 5. Компанийн дотоод аудитын албаны хагас жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх,
 6. Компанийн хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг үнэлэх, дүгнэлт гаргах,
 7. “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”, “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу компанийн засаглалын кодекст заасан мэдээллийг хэрхэн хүргэж байгаад хяналт тавьж дүгнэлт өгөх,

Цалин, урамшууллын хороо нь:

1. Компанийн ТУЗ-ын гишүүдийн цалин, урамшууллын үнэлгээг шинэчлэн батлах,
2. ТУЗ-ын 2022 оны төсвийн зарцуулалтын тайлан, 2023 оны ТУЗ-ын гишүүдийн цалин, ТУЗ-ын төсөв батлах,

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны ХЭХ-аас баталсан ТУЗ-ын төсөв, ТУЗ-ын “2023 оны сургалтын төлөвлөгөө”-ний дагуу Gare, Хан голомт, Дэйл карне, Axiom, СТСТ-Cognitively-Based Compassion Training зэрэг сургалтын төвүүдтэй гэрээ байгуулж гэрээний дагуу ТУЗ-ын нийт гишүүд, ТУЗ-ын нарийн бичгийн даргыг хариуцсан чиг үүрэг, мэргэжлийнх нь дагуу компанийн холбогдох ажилтнуудын хамт сургалтанд хамруулсан.

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулж явуулсан “Компанийн засаглал ба түүний ач холбогдол” сэдэвт хэлэлцүүлэг, уулзалтанд ТУЗ-ын нарийн бичгийн даргыг хамруулж оролцуулсан.

Мөн тайлант хугацаанд Техник импорт ХК-ийн “Компанийн засаглалын кодекст”-ийн хэрэгжилтийг СЗХ, МХБ ХК-иас ирүүлсэн үнэлгээний дагуу гаргаж тайланг СЗХ болон МХБ ХК-д хүргүүлж ажилласан. Компанийн засаглалын кодексийн анхны үнэлгээгээр Хөрөнгийн бирж ХК-д бүртгэлтэй 2 дугаар зэрэглэлийн хувьцаат компаниудиаас эхний ТОП-10-ийн 8-р байранд, давтан үнэлгээгээр 21-р байранд орж үнэлэгдсэн.

3. Компанийн гүйцэтгэх удирдлага

Тайлант хугацаанд компанийн Гүйцэтгэх удирдлага нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажилласан.

Техник импорт ХК-ийн Гүйцэтгэх захирлаар 2006 оноос хойш Дашдондог овогтой Ганцэцэг ажиллаж байна.

Тайлант хугацаанд Техник импорт ХК нь үйл ажиллагаандаа ISO-9001-2015 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж ажилласан ба дараахь бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа зохион байгуулж ажилласан.

1. Гүйцэтгэх захирал
2. Дотоод аудитын алба
3. Захиргаа, хүний нөөцийн алба
4. Дэмжих үйлчилгээний алба
5. Инженер техникийн алба
6. Санхүү, бизнес хөгжлийн алба
7. Бизнес хөгжлийн алба

Компанийн дотоод аудитын алба нь 2012 онд анх байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд компанийн бүтэц, зохион байгуулалтын дагуу Гүйцэтгэх захирлын шууд удирдлага дор үйл ажиллагаагаа явуулдаг.

Компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 сарын 10-ны өдрийн А-08 тоот тушаалаар “Санхүүгийн болон чанарын дотоод аудитын журам”-ыг шинэчлэн баталж компанийн үйл ажиллагаанд тус журмыг мөрдөн ажиллуулсан бөгөөд 2023 оны төлөвлөгөөний дагуу 2023 онд

санхүүгийн болон чанарын дотоод аудитыг компанийн бүх албадын хэмжээнд хийж явуулсан. Ингэснээр компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт учирч болзошгүй эрсдэл байгааг тодорхойлж гарган үнэлэх, тэдгээрийн шалтгааныг тогтоох, сэргийлэх арга хэмжээ авах, улмаар чанартай ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг зах зээлд болон хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд хүргэх ажиллагаанд тавигдах стандартыг бий болгох, хэвшүүлэхэд ихээхэн үр дүнгээ өгсөн.

Тайлант хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас батлагдсан “2023 оны бизнес төлөвлөгөө”-ний дагуу компанийн удирдлагаас цемент, мотоцикл, битум, арматур, хүнд даацын дугуйг зах зээлд худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажилласан.

Тайлант хугацаанд компанийн түүхт 65 жилийн ой болж ойгоо ажлын амжилтаар угтсан, компанийн үйл ажиллагаанд ОУ-ын чанарын менежментийн ISO-9001 удирдлагын стандартыг амжилттай нэвтрүүлж баталгаажуулсан он жил байлаа.

Энэ хугацаанд компанийн үйл ажиллагааг төр засгийн бодлогод нийцүүлэн улс орондоо гадаад худалдаа, барилга, замын чиглэлээр дэд бүтцийг хөгжүүлэх, импортыг орлох онцгой бараа бүтээгдэхүүнийг өөрийн оронд үйлдвэрлэх, олон улсын тээвэр зуучийн салбар, хөдөө аж ахуйн салбарт оруулж байгаа хувь нэмрийг төр засгаас өндрөөр үнэлж компанийн Гүйцэтгэх захирал Д.Ганцэцэгийг Монгол Улсын “ХУДАЛДААНЫ ГАВЬЯАТ АЖИЛТАН” цол тэмдгээр шагнасан явдал нь компанийн хамт олон, нийт ажилтнуудын урам зориг, идэвх чармайлтыг нэмэгдүүлсэн онцгой тэмдэглэлт түүхэн үйл явдал болсон.

Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

Тайлант хугацаанд компани дэвшүүлсэн зорилгондоо хүрэхийн төлөө нөөц, боломжоо ашиглан хичээж ажилласан боловч инфляцийн өсөлт, байгалийн давагдашгүй хүчин зүйл, бэлэн мөнгөний хомсдол үүссэнээс шалтгаалан хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн худалдан авах чадвар буурсан нь компанийн бараа бүтээгдэхүүний борлуулалтанд тухайлбал цемент, мотоцикл, арматурын борлуулалтанд нөлөөлж борлуулалт буурсан.

Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

2023 оны 03 дугаар сарын 09-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иас ирүүлсэн судалгаагаар: Нийт хувьцааны тоо: 1, 446, 755
Хувьцаа эзэмшигчдийн тоо: 459

№	Овог нэр	Хувьцааны төрөл	Эзэмшиж буй хувьцааны тоо /ширхэг/	Эзэмшиж буй хувь
1.	Д.Ганбат	Энгийн	475161	32,84%
2.	Д.Ганцэцэг	Энгийн	455736	31,5%
3.	Г.Содбилэг	Энгийн	480300	33,2%

Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлээгүй тул татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.

Ногдол ашгийн мэдээлэл

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл жил бүр холбогдох хууль, журамд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ногдол ашгийн талаарх ТУЗ-ын тогтоол, шийдвэр, ногдол ашгийн тайланг танилцуулж тайлагнадаг.

Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2022 онд ногдол ашиг хуваарилах эсэх асуудлаар 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдөр хуралдаж шийдвэр гаргасан.

Техник импорт ХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 2022 оны нэгж хувьцаанд 2000 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02-р сарын 14-ний өдрийн хурлын тогтоолыг танилцуулж хэлэлцүүлж батлуулсан.

2022 оны ногдол ашиг олгох талаар 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолыг хэрэгжүүлэхээр Техник импорт ХК-ийн удирдлагаас дараах ажлыг зохион байгуулж ажилласан. Үүнд:

1. Компанийн нийт 1 446 755 ширхэг хувьцаанд 2 893 510 000 төгрөгийн ногдол ашиг олгохоос Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолыг үндэслэн 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр компанийн 11 хувьцаа эзэмшигчээс ногдол ашгаа авах талаар гаргасан өргөдөл, хүсэлтийг үндэслэн 1 433 918 ширхэг хувьцаанд ногдох 2 867 836 000 төгрөгийг компани дээрээс олгосон.
2. Техник импорт ХК-иас “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-тай 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан 03/26 тоот “ҮЦТХТ ХХК-иар зуучлуулан ногдол ашиг тараалгах гэрээ”-ний дагуу 2022 оны ногдол ашгаа аваагүй компанийн нийт 448 хувьцаа эзэмшигчийн 12 837 /Арван хоёр мянга найман зуун гучин долоо/-н ширхэг хувьцаанд ногдох 24 378 600 төгрөг /Хорин дөрвөн сая гурван зуун далан найман мянга зургаан зуу/-ийг ҮЦТХТ ХХК-ийн Төрийн банк дахь 102 100 549 647 тоот дансанд 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр шилжүүлж байршуулсан.

МУ-ын Компанийн тухай хууль, СЗХ болон МХБ ХК-ийн холбогдох журамд заасны дагуу болон Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж ХК-д 2022 оны ногдол ашгийн тайланг тус тус хүргүүлж ажилласан.

Тайлант хугацаанд Техник импорт ХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн “Даалгавар өгөх тухай” албан бичиг, Монголын хөрөнгийн бирж ХК-иас ирүүлсэн “Хамтран ажиллах тухай” албан бичигт заасан хугацаанд дараах компанийн мэдээллийг СЗХ, МХБ ХК-д хүргүүлж ажилласан. Үүнд:

1. Техник импорт ХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
2. Техник импорт ХК-ийн 2022 оны ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ын шийдвэр, тогтоол
3. Техник импорт ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах талаар ТУЗ-аас гаргасан шийдвэр, тогтоол, холбогдох баримт материалын хамт
4. Техник импорт ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, тогтоол, холбогдох баримт материалын хамт
5. Техник импорт ХК-ийн 2023 оны санхүүгийн жилийн эцсийн тайланд хийсэн аудитын компанийн дүгнэлт,
6. 2022 оны ногдол ашгийн тайлан
7. Техник импорт ХК-ийн 2023 оны хагас жилийн санхүүгийн тайлан
8. Техник импорт ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан
9. Техник импорт ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан
10. Техник импорт ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн үнэлгээний тайлан, холбогдох материалууд.

Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

Тайлант хугацаанд компаниас нийгмийн хариуцлагын чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. Компанийн ахмад ажилчдыг “Ахмадын баярын өдөр”-өөр хүлээн авч компанийн бэлгийг гардуулж уулзалт зохион байгуулж тэмдэглэсэн.
2. Компанийн нийт ажилчдыг эрүүл мэндийн бүрэн шинжилгээнд хамруулж холбогдох зардлыг компаниас гаргасан.
3. Компанийн 3 ажилтанд байрны урьдчилгаа төлбөрийн 30%-ийг олгосон.
4. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр 40 ширхэг хүүхдийн бэлгийг харьяа дүүргийн 28-р хороонд өгсөн.
5. Шинэ өргөө хот тохижилтын 4 ажилтанд 250000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.
6. Хүүхдийн баяр болон тэмдэглэлт ойг угтаж компанийн ажилчдын хүүхдүүдийн дунд гар зураг, эссэ бичих, спортын тэмцээн уралдаан зохион байгуулж мөнгөн шагналаар шагнасан.

Овог, нэр: Д.Ганцэцэг

Албан тушаал: “Техник импорт” ХК-ийн

Гүйцэтгэх захирал



Овог, нэр: П.Шаравхорол

Албан тушаал: “Лидер экаунт аудит”
ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2024.04.30

Овог, нэр: О.Бүжинлхам

Албан тушаал: ТУЗ-ын нарийн бичгийн дарга

Гарын үсэг: